

---

**ОЮУ ТОЛГОЙН ДАЛД УУРХАЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ,  
САНХҮҮЖИЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

---

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК**

**ТУРКОЙС ХИЛЛ РЕСУРСЕС ЛИМИТЕД  
ТИ ЭЙЧ АР ОЮУ ТОЛГОЙ ЛТД  
ОЮУ ТОЛГОЙ НИДЕРЛАНД БИ ВИ  
РИО ТИНТО ИНТЕРНЭШНЛ ХОЛДИНГС ЛИМИТЕД**

**БОЛОН**

**ОЮУ ТОЛГОЙ ХХК**

**2015 ОНЫ 5 ДУГААР САРЫН 18**

**ЭХ СУРВАЛЖ: [WWW.ILTODGEREE.MN](http://WWW.ILTODGEREE.MN)**

## ОЮУ ТОЛГОЙН ДАЛД УУРХАЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Оюу Толгойн Далд Уурхайн Бүтээн Байгуулалт, Санхүүжилтийн энэхүү төлөвлөгөөг (цаашид “**Төлөвлөгөө**” гэх) 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдөр

Монгол Улсын Засгийн Газар;

Эрдэнэс Оюу Толгой ХХК (“**ЭОТ**”) (цаашид Монгол Улсын Засгийн Газартай хамтад нь “**Монголын тал**” гэх);

БОЛОН

Туркойс Хилл Ресурсес Лимитед, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд болон Оюу Толгой Нидерланд Би Ви, (цаашид хамтад нь “**Туркойс Хилл**” гэх) болон Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед (цаашид “**Рио Тинто**” гэх);

БОЛОН

Оюу Толгой ХХК (цаашид “**ОТ ХХК**” гэх),

(цаашид хамтад нь “**Талууд**” гэх)-ийн хооронд байгуулав.

### ҮНДЭСЛЭЛ:

- (А) Талууд болон тэдгээрийн хамааралтай этгээдүүдийн хооронд 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр Хөрөнгө оруулалтын гэрээг (“**ХөОГ**”), ОТ ХХК-ийн хувьцаа эзэмшигчидийн хооронд 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр Нэмэлт Өөрчлөлт Оруулж Дахин Тодотгосон Хувь Нийлүүлэгчдийн гэрээг (“**НӨОДТХНГ**”) (2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан Хувь нийлүүлэгчдийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж дахин тодотгосон) тус тус байгуулсан;
- (В) ХөОГ болон НӨОДТХНГ-нд заасны дагуу, ОТ ХХК нь Монгол Улсын Өмнөговь аймагт байрлах Оюу Толгой төслийн бүтээн байгуулалт, ашиглалтын үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа;
- (С) ЭОТ нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 348 дугаар тогтоол, Эрдэнэс МГЛ ХХК (одоо Эрдэнэс Монгол ХХК)-ийн ТУЗ-ийн 2011 оны 28 дугаар тогтоолын дагуу ОТ ХХК дахь Монгол Улсын Засгийн газрын хувь эзэмшлийг шилжүүлэн авч, холбогдох эрхийг хэрэгжүүлэх этгээдээр томилогдсон;

зэргийг үндэслэн, энэхүү Төлөвлөгөөнд заасан харилцан хүлээх үүргүүдийг Талууд дараах байдлаар тохиролцов. Үүнд:

## 1. **НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

Энэхүү Төлөвлөгөөнд хэрэглэгдсэн нэр томъёог тухайн зүйл заалтад өөрөөр заагаагүй тохиолдолд дор дурдсан утгаар ойлгоно:

**“НӨОДТХНГ”** –ийн тодорхойлолтыг энэхүү Төлөвлөгөөний Үндэслэл хэсэгт зааснаар ойлгоно.

**“Аудитын хороо”** гэж НӨОДТХНГ-ний 5.9 заалтын дагуу “Оюу Толгой” компанийн ТУЗ-өөс байгуулсан Аудит, Санхүү, Хангамжийн хороог хэлнэ.

**“Хөрөнгө оруулалтын зардал”** –ын тодорхойлолтыг НӨОДТХНГ-нд заасан утгаар ойлгоно.

**“Далд уурхайн үе шатны Хөрөнгө оруулалтын зардал”** гэж Далд уурхайн үе шатны бүтээн байгуулалттай холбоотой Компаниас гарч байгаа, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу хөрөнгө оруулалтын зардал гэж тодорхойлогдох бүх зардал, өртөг, шимтгэлийг хэлэх бөгөөд үүнд компаниас гарах урсгал хөрөнгө оруулалт зэрэг бусад зардлыг оруулахгүй.

**“ЭОТ”** гэж Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийг хэлнэ.

**“Техник эдийн засгийн үндэслэл”** буюу **“ТЭЗҮ”** -ийг энэхүү Төлөвлөгөөний 4.2-т тодорхойлсоноор ойлгоно.

**“Хөрөнгө оруулалтын гэрээ”** буюу ХөОГ-г энэхүү Төлөвлөгөөний Үндэслэл хэсэгт заасан утгаар ойлгоно.

**“Менежментийн төлбөр”** -ийг НӨОДТХНГ-ний 7.4-т заасан утгаар ойлгоно.

**“Металс Дэйли”** гэж Платс (Макграв Хилл Файнаншл Инк-ийн салбар нэгж)-аас Металс Дэйли нэрээр өдөр тутам эрхлэн гаргадаг тайланг, эсвэл Платс-аас уг тайлангийн оронд гаргасан аливаа хэвлэлийг, эсвэл хэзээ нэгэн цагт уг тайлан хэвлэгдэхээ больсон тохиолдолд Талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр сонгон авсан, энэхүү Төлөвлөгөөний 6.3-т заасан зах зээлийн үнийн индексүүдээр тайлан гаргадаг өөр тайланг ойлгоно.

**“Монголын тал”** гэж Монгол Улсын Засгийн газар болон ЭОТ-г хэлнэ.

**“Ил Уурхайн Үе Шат”** гэж Төлөвлөгөөний 4(а)-д тодорхойлсоныг хэлнэ.

**“Оюу Толгой компанийн ТУЗ”** гэж ОТ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг хэлнэ.

**“ОТ ХХК”** гэж Оюу Толгой ХХК-ийг хэлнэ.

**“Оюу Толгой төсөл”** гэж ХөОГ-ний 16.34-т тодорхойлсоныг хэлнэ.

**“Бүтээгдэхүүн”** гэдгийг ХөОГ-нд заасан утгаар нь ойлгоно.

**“Рио Тинто”** гэж Рио Тинто ПиЭлСи, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед болон тэдгээрийн хамааралтай этгээдүүдийг хэлнэ.

**“Төслийн санхүүжилтийн баталгааны шимтгэл”** гэж Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед, Рио Тинто Саут Ийст Азиа Лимитед болон Туркоис Хилл-ийн

хооронд 2012 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр байгуулсан Санамж бичигт заасны дагуу Далд уурхайн Төслийн санхүүжилт авахад Рио Тинтогоос төслийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэх баталгаа гаргаж дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан Рио Тинто-д төлөх шимтгэлийг хэлнэ.

“Хувьцаа эзэмшигчид” гэж НӨОДТХНГ-ний 25 дугаар зүйлд заасан “Хувь нийлүүлэгч” гэсэн тодотголтой адил утгатай байна.

“Туркойс Хилл” гэж Туркойс Хилл Ресурсес Лимитед, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд болон Оюу Толгой Нидерланд Би Ви-г хамтад нь хэлнэ.

“Далд уурхайн ТЭЗҮ” гэж Далд уурхайн үе шатны бүтээн байгуулалтын Техник эдийн засгийн үндэслэлийг хэлнэ.

“Далд уурхайн Төслийн санхүүжилт” гэж Төлөвлөгөөний 4.7(а)-д тодорхойлсныг хэлнэ.

“Далд уурхайн Үе шат” гэж Төлөвлөгөөний 4(b)-д тодорхойлсныг хэлнэ.

“2010 оны ТЭЗҮ” гэж Оюутолгой төсөлд зориулан 2010 онд боловсруулсан ТЭЗҮ-г хэлнэ.

## 2. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 2.1 Талууд хоорондоо үүсээд буй асуудлууд дээр ойлголцон, нэгдсэн шийдвэрт хүрч, ОТ ХХК-ийн хэрэгжүүлж буй Оюу Толгой төслийн бүтээн байгуулалтыг гүйцээх ажлыг шуурхайлах хүсэл эрмэлзлэлтэй байна.
- 2.2 ОТ ХХК нь Монгол Улсын хууль тогтоомж болон ХөОГ-нд заасны дагуу Монгол Улсын холбогдох бүх хууль тогтоомжийг мөрдөж ажиллах үүрэгтэй ба ингэхдээ ХөОГ-нд заасан эрх зүйн болон татварын орчныг тогтворжуулах тухай заалтуудыг баримтална. Талууд:
  - (a) ХөОГ болон НӨОДТХНГ-ний заалт, нөхцлүүдийг дагаж мөрдөхөө нотолж байна.
  - (b) Далд уурхайн ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу Оюу Толгой төслийн эдийн засгийн үр ашгийн хуваарилалт нь 2010 оны ТЭЗҮ-д тооцсон тооцоололтой нийцэж байгаа ба үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар нь Оюутолгой төсөл хэрэгжих хугацаанд төслийн нийт үр ашгийн 53 гаруй хувийг татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ногдол ашиг хэлбэрээр авахыг цохон тэмдэглэж байна.
- 2.3 ОТ ХХК нь Оюу Толгой компанийн ТУЗ-ийн удирдлага дор, Монгол Улсын хууль тогтоомж, ХөОГ, НӨОДТХНГ-ний дагуу, санхүү, эдийн засгийн зарчмуудыг удирдлага болгон, ашиг олох зорилго бүхий аж ахуй нэгжийн хэлбэрээр ажиллана гэдгийг Талууд тэмдэглэж, бататгав.
- 2.4 ОТ ХХК-ийн засаглал, санхүүжилт, санхүүгийн үйл ажиллагааг хянаж удирдах зорилгоор:

- (a) НӨОДТХНГ-нд заасны дагуу ОТ ХХК-ийн данс бүртгэлийг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт болон НӨОДТХНГ-ний 8.3-т заасан нягтлан бодох бүртгэлийн стандарт шаардлагын дагуу аудитын олон улсын стандарт, туршлагад нийцүүлэн жилд нэгээс доошгүй удаа Оюу Толгой компанийн ТУЗ-өөс Монгол Улсын хуулийн дагуу томилсон хөндлөнгийн аудитын Монгол компаниар шалгуулна;
- (b) Жил тутам хийгдэх эдгээр аудитаас гадна Далд уурхайн үе шатны хөрөнгө оруулалтын зардлын хяналт, тайланг тусгайлан хянах зорилгоор Оюу Толгой компанийн ТУЗ шаардлагатай тохиолдолд нэмэлт аудит хийлгэх хүсэлт гаргаж болно;
- (c) ОТ ХХК-ийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах зорилгоор засаглалын дараах арга хэмжээнүүдийг шинээр нэвтрүүлсэн. Үүнд:
  - (i) Аудитын хороо зарим (худалдан авалт, хөрөнгө оруулалтын зарцуулалт, санхүүжилт зэрэг) үйл ажиллагаанд нарийвчилсан хяналт тавьж ажилласан.
  - (ii) Үйл ажиллагааны явцад хяналт тавих сар тутмын хурлуудыг (хөрөнгө оруулалтын зарцуулалт зэрэг) зохион байгуулдаг болсон.

2.5 Аудитын хорооны даргаар зохих шалгуурт нийцэх Оюу Толгой компанийн ТУЗ-ийн гишүүнийг Монголын талаас нэр дэвшүүлэн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл ажиллуулна.

### **3. ДОТООДЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ**

3.1 Далд уурхайн үе шатны бүтээн байгуулалт, үйл ажиллагааны зардал, Монгол Улсын Засгийн газарт төлөх төлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор Монгол улсын нутаг дэвсгэрт зарцуулагдах зардлын тооцоо, бүтээн байгуулалтын ажлын болон зардлын төлөвлөгөөг дараах хүснэгтэд тойм байдлаар үзүүлэв. Энэхүү хүснэгтэд танилцуулсан тоо баримтууд нь төслийн цар хүрээ, зардал, график төлөвлөгөө, техникийн үзүүлэлтүүд, зах зээлийн нөхцөл байдал зэрэг Далд уурхайн ТЭЗҮ-д тусгагдсан өгөгдлүүд дээр үндэслэн тооцоологдсон болно. Монгол улсын дотоодод зарцуулах зардлыг Оюу Толгой компанийн хуримтлуулсан туршлага, бүтээн байгуулалтын ажлын төлөвлөгөө зэрэгт тулгуурлан тооцож энд үзүүлсэн байгаа ба зохих чанарын шаардлагыг хангах, зардлын хувьд хэмнэлттэй дотоодын ханган нийлүүлэгчдээс хамаарна гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Бүх тоог цаг хугацааны энэ мөчлөг дэх нөхцөл байдал дээр үндэслэж тооцсон бөгөөд тэдгээрт баталгаа

гаргахгүй тул бодит гүйцэтгэлээр эдгээр тооцооллоос зөрүүтэй дүн гарч болно.

Тэрбум ам доллар	1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	5-р жил	6-р жил	7-р жил	Нийт
<b>Хөрөнгө оруулалтын зардал</b>								
Далд уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын зардал	0,3	1,1	1,0	1,1	0,7	0,5	0,1	4,7
Урсгал хөрөнгө оруулалтын зардал	0,1	0,1	0,0	0,1	0,4	0,4	0,5	1,5
Хөрөнгө оруулалтын зардалд ногдуулах НӨАТ ба бусад татвар	0,0	0,1	0,1	0,1	0,1	0,1	0,1	0,6
<b>Хөрөнгө оруулалтын нийт зардал</b>	<b>0,4</b>	<b>1,2</b>	<b>1,1</b>	<b>1,3</b>	<b>1,2</b>	<b>1,0</b>	<b>0,6</b>	<b>6,8</b>
<b>Дотоодод шууд зарцуулахаар тооцсон зардал</b>								
Монгол Улс дахь үйл ажиллагааны зардал	0,6	0,6	0,6	0,6	0,6	0,6	0,7	4,3
Монгол Улс дахь хөрөнгө оруулалтын зардал	0,2	0,5	0,4	0,5	0,4	0,4	0,2	2,5
Монгол Улсын Засгийн газарт шууд төлөх төлбөр	0,3	0,3	0,3	0,3	0,3	0,3	0,4	2,2
<b>Монгол улсад шууд зарцуулах нийт дүн</b>	<b>1,1</b>	<b>1,3</b>	<b>1,2</b>	<b>1,3</b>	<b>1,4</b>	<b>1,3</b>	<b>1,3</b>	<b>9,0</b>

- 3.2 ХөОГ-ний 4 дүгээр бүлэгт заасны дагуу ОТ ХХК нь Өмнөговь аймаг, Ханбогд сум, Манлай сум, Баян-Овоо сум, Даланзадгад сумдтай Хамтын ажиллагааны гэрээ байгуулахыг Талууд бүрэн дэмжиж байна. Уг Хамтын ажиллагааны гэрээний дагуу ОТ ХХК жил бүр 5 сая хүртэлх ам.долларыг Өмнөговийн бүс нутгийн хөгжилд зориулан олгоно.
- 3.3 ОТ ХХК нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээд тэр дундаа Өмнөговь аймагт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд давуу эрх олгож тэдний нийлүүлж буй бараа үйлчилгээг болон Монгол улсад үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материал, сэлбэг хэрэгсэл зэргийг цаг хугацаа, зардал, тоо хэмжээ, чанарын хувьд өрсөлдөхүйц байх нөхцөлтэйгөөр, тэргүүн ээлжинд худалдаж авна. Оюутолгой төсөлд шаардлагатай ачаа тээврийн үйлчилгээг авахдаа дотоодын ханган нийлүүлэгчдэд давуу тал олгоно. ОТ ХХК-ийн энэхүү үүргийн биелэлтэд Аудитын хороо хяналт тавьж ажиллана.
- 3.4 Энэхүү Төлөвлөгөөг баталснаас 30 хоногийн дотор, Таван Толгойн цахилгаан станцаас цахилгаан эрчим хүч худалдаж авахтай холбогдуулан, ОТ ХХК-ийн хүлээсэн үүрэгт дэмжлэг үзүүлэх үүднээс Төлбөрийн чадамж сайжруулах механизмын төсөөллийг Таван Толгойн цахилгаан станцын Төсөл хэрэгжүүлэх нэгжид бэлтгэн өгөхөөр, ОТ ХХК болон Туркойс Хилл компаниуд тогтов. Төлбөрийн чадамж сайжруулах механизмын төсөөллийг Туркойс Хилл компанийн зүгээс өгөхөөр тооцож байгаа ба Туркойс Хилл бусад холбогдох этгээдээс эцсийн байдлаар дэмжлэг үзүүлэх эсэх, түүний хэмжээг Таван Толгойн цахилгаан станцын төслийн хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч нартай хийх яриа хэлэлцээнээс хамааран шийднэ.
- 3.5 Зэс хайлуулах үйлдвэрийг Монгол Улсад барьж байгуулах, ажиллуулах эдийн засгийн боломжийн талаарх судалгааны тайланг ОТ ХХК нь 2016 оны 9 дүгээр сараас өмнө боловсруулна. Энэхүү судалгааг гаргаснаар ОТ ХХК-ийг ХөОГ-ний 3.19-ийн дагуу хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэнд тооцох бөгөөд энэ нь ОТ ХХК-ийн ХөОГ-ний дагуу хүлээсэн бусад эрх, үүрэгт нөлөөлөхгүй.

#### 4. ДАЛД УУРХАЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ХөОГ-ний 9.6-д заасны дагуу Оюу Толгой төслийг үе шаттайгаар хэрэгжүүлж болно. Энэхүү Төлөвлөгөөний зорилгын хүрээнд:

- (a) **Ил уурхайн Үе шат** гэж Оюу Толгойн ил уурхай, баяжуулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцийг барьж байгуулах, ашиглалтанд хүлээлгэн өгөх, мөн далд уурхайн босоо амны нэвтрэлтийн урьдчилсан ажлууд болон далд уурхайн хэвтээ малталт нэвтрэлтийн урьдчилсан ажлуудыг ойлгоно;
- (b) **Далд уурхайн Үе шат** гэж Далд уурхайн ТЭЗҮ-д заасны дагуу Хойд Хюго ордыг ашиглах далд уурхайн 1 дүгээр давхарын бүтээн байгуулалтын ажил, далд уурхайгаас олборлох хүдрийг боловсруулах зорилгоор баяжуулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцэд хийх өөрчлөлтийг ойлгоно. Эргэлзээ үүсгэхгүй байх үүднээс, Хойд Хюго ордын 1 дүгээр давхараас бусад далд уурхайн аливаа бүтээн байгуулалтын ажлыг Далд уурхайн Үе шатанд оруулж тооцохгүй.

4.2 **Техник, эдийн засгийн үндэслэл** (ТЭЗҮ) гэж уул уурхайн төслийн санхүүгийн үр ашгийг тогтоох зорилгоор ашигт малтмалын ордын геологи, инженерийн шийдэл, хууль эрх зүй, үйл ажиллагаа, эдийн засаг, нийгэм, байгаль орчны болон бусад холбогдох хүчин зүйлсийг нарийвчлан тооцоолсон цогц судалгааг ойлгоно. Техник, эдийн засгийн үндэслэл нь тодорхойгүй, магадлашгүй хүчин зүйлсээс хамаарч өөрчлөгдөж болзошгүй төсөөллүүдэд тулгуурласан, бодит гүйцэтгэл нь ТЭЗҮ-д зааснаас өөр гарч болох тооцооллуудаас бүрдэх бөгөөд эрхзүйн хувьд заавал мөрдөх баримт бичиг биш болохыг Талууд хүлээн зөвшөөрөв.

4.3 Ил уурхайн Үе шаттай холбогдох зардлууд 2010 оны ТЭЗҮ-д зааснаас зөрсөн асуудлыг бүрэн ойлгох үүднээс удаа дараа хийсэн шалгалт, аудитууд, түүний дотор Монгол Улсын Засгийн газрын гурван сайдын хамтарсан тушаалын дагуу гүйцэтгэсэн шалгалтын дараагаар Талууд дараах ойлголцолд хүрэв. Үүнд:

- (a) Ил уурхайн Үе шатны нийт зардал нь батлагдсан хөтөлбөр, төсвийн дагуу зарцуулагдсан бөгөөд тэдгээрийг ОТ ХХК-ийн санхүүгийн тайлангуудад үнэн зөвөөр тусгаж эдгээр тайлангуудаа Сангийн яаманд мэдүүлсэн;
- (b) Зардлын зөрүү нь шаардлагатай хэмжээнд тайлбарлагдсан бөгөөд Ил уурхайн Үе шатны зардалтай холбоотой сөрөг үр дагавар бүхий дүгнэлт, Талуудын хооронд үл ойлголцол байхгүй.

4.4 Монгол Улсын Сангийн яам нь энэхүү Төлөвлөгөөг байгуулснаас ажлын 5 (таван) хоногийн дотор ОТ ХХК-ийн мэдүүлсэн 2010, 2011, 2012, 2013, 2014 онуудын санхүүгийн тайлангуудыг хүлээж авч баталгаажуулна.

4.5 Энэхүү Төлөвлөгөөний 4.4-д заасны дагуу ОТ ХХК-ийн санхүүгийн тайлангуудыг Монгол Улсын Сангийн яам хүлээн авснаас хойш ажлын 2 хоногийн дотор Монгол Улсын Татварын Ерөнхий газар нь:

- (a) ХөОГ-ний 2.33-т заасан хөрөнгө оруулалтын татварын

хөнгөлөлтийн ХөОГ-ний 2.26-ын дагуу тооцсон хуримтлагдсан дүн нь 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 646'260'000 ам.доллараос багагүй байгааг баталгаажуулна;

(b) ХөОГ-ний 2.26-ын дагуу тооцсон ОТ ХХК-ийн шилжүүлэн тооцох алдагдалын дүн нь 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 256'580'000 ам.доллараос багагүй байгааг баталгаажуулна.

4.6 ОТ ХХК нь менежментийн төлбөр болон бусад Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадуур үзүүлсэн үйлчилгээнд ногдуулах НӨАТ-ыг (Монгол Улсын холбогдох төрийн эрх бүхий байгууллага аль эсвэл шүүх нь НӨАТ-ын тухай хуулийн оршин суугч бус этгээдээс суутгах өөрөө тайлагнах татварын тухай заалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадуур үзүүлсэн үйлчилгээнд хамаарахгүй тухай шийдвэр гаргах аль эсвэл тогтоох) хүртэл үргэлжлүүлэн төлсөн хэвээр байх болно.

4.7 Талууд Далд уурхайн Үе шатны бүтээн байгуулалтыг шуурхай эхлүүлэх эрмэлзэлтэй байгаа хэдий ч зөвхөн дараах нөхцлүүд хангагдсаны дараа Далд уурхайн Үе шатны бүтээн байгуулалт эхлэх боломжтойг зөвшөөрөв. Үүнд:

(a) Далд уурхайн Үе шатыг санхүүжүүлэх гуравдагч этгээдийн төслийн санхүүжилтийг ("Далд уурхайн Төслийн санхүүжилт") авах шаардлагуудыг ОТ ХХК хангасан;

(b) Далд уурхайн Үе шатыг Рио Тинто, Туркойс Хилл, ОТ ХХК-ийн ТУЗ тус бүрээр батлуулсан байх.

4.8 Талууд менежментийн төлбөрийг тооцоолохдоо Далд уурхайн үе шатны хөрөнгө оруулалтын зардалд НӨОДТХНГ-нд заасан 6%-иар бус, 3%-иар тооцохыг зөвшөөрөв.

## **5. ДАЛД УУРХАЙН ҮЕ ШАТНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХ ТОХИРОЛЦОО**

5.1 Далд уурхайн Төслийн санхүүжилтийг багтаасан санхүүжилтийн цогц төлөвлөгөөний зарчмууд дээр Хувьцаа эзэмшигчид нэгдсэн ойлголцолд хүрэв. ОТ ХХК-ийн бизнесийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд, зэс, алтны үнийн хэлбэлзлэл зэрэг хүчин зүйлсийг харгалзан шаардагдах санхүүжилтийн хэрэгцээг тодорхойлно.

5.2 Далд уурхайн Төслийн санхүүжилтийн талаарх шийдвэрийг Рио Тинто, Туркойс Хилл, ОТ ХХК тус бүрийн ТУЗ болон ОТ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчид гаргана. Оюу Толгой компанийн ТУЗ-ийн Далд уурхайн Төслийн санхүүжилтийг батлах тухай шийдвэр нь Төслийн санхүүжилтийн зээлдүүлэгчдийн шаардлага болгосны дагуу санал нэгтэй баталсан шийдвэр байна.

5.3 Далд уурхайн Төслийн санхүүжилтээс орж ирэх бүх мөнгөн хөрөнгө (санхүүжилтийн болон баталгааны шимтгэл, холбогдох татвар хураамжийг хассаны дараах) болон үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогыг нэн тэргүүнд Хувь нийлүүлэгчийн Одоогийн зээл, Хувь нийлүүлэгчийн Өрийн хуримтлагдсан хүү (НӨОДТХНГ-нд тодорхойлсоны



дагуу), Хувь нийлүүлэгчийн Өрийн үндсэн дүнгийн үлдэгдлийг эргэн төлөхөд зарцуулна. Энэхүү Төлөвлөгөөний 5.5-д заасны дагуу ОТ ХХК нь Далд уурхайн Үе шатны бүтээн байгуулалтын ажилд зарцуулах зорилгоор эдгээр санхүүжилтийг дараа нь дахин зээлж болно.

5.4 ОТ ХХК нь Далд уурхайн Төслийн санхүүжилтээс татан авч, хүлээн авсан бүх мөнгөн дүн болон Рио Тинтод төвлөрүүлсэн аливаа санхүүжилтийн үлдэгдэл дүнгийн бүртгэлийг өөрийн санхүүгийн бүртгэл тооцоонд ил тод хөтөлж, Оюу Толгой компанийн ТУЗ-д тайлагнана.

5.5 Санхүүжилтийн цогц төлөвлөгөөнд дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

(a) Төслийн санхүүжилт (үүнд Далд уурхайн Төслийн Санхүүжилт багтана), бусад хэлбэрийн банкны санхүүжилт, бүтээгдэхүүн борлуулалтын тохиролцоо болон санхүүжилтийн бусад арга хэлбэрээр нийт 6 хүртэлх тэрбум ам.долларын санхүүжилтийг гуравдагч этгээдүүдээс татан төвлөрүүлнэ.

(b) ОТ ХХК нь мөнгөн хөрөнгийн зохистой удирдлагын арга хэмжээг (“өрийн нэгтгэл”) хэрэгжүүлж ОТ ХХК-ийн санхүүжилтийн зардлыг багасгахыг зорьж ажиллана. Үүнд:

(i) Далд уурхайн Төслийн санхүүжилт болон үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогоос илүү гарсан мөнгөн хөрөнгөөр Хувь нийлүүлэгчийн Одоогийн зээл ба Хувь нийлүүлэгчийн өрийг эргэн төлнө;

(ii) Туркойс Хилл нь (i)–р заалтад заасан урьдчилан төлсөн бүх мөнгөн хөрөнгийг Далд уурхайн Үе шатны бүтээн байгуулалтад шаардагдах хүртэл Рио Тинто группийн тайлан тэнцэлд түр бүртгэнэ. Ингэснээр ОТ ХХК-ийн Рио Тинтод төлөх Төслийн санхүүжилтийн баталгааны шимтгэл дүйцэх хэмжээгээр буурна (доор (v) заалтад заасны дагуу). Рио Тинтогийн тайлан тэнцэлд бүртгэгдэх мөнгөн хөрөнгийн нийт дүн 4.2 тэрбум ам.доллар эсвэл Далд уурхайн Төслийн санхүүжилтийн зээлийн нийт дүнгээс ихгүй байна.

(iii) Далд уурхайн Үе шатны бүтээн байгуулалтад ашиглах зорилгоор ОТ ХХК-иас хүсэлт гарган Далд уурхайн Төслийн санхүүжилтээс босгосон нийт мөнгөн хөрөнгийг (санхүүжилтийн болон амлалтын шимтгэл, холбогдох татвар хураамжийг хассаны дараах) Хувь нийлүүлэгчийн Одоогийн зээл болон Хувь нийлүүлэгчийн Өртэй адил нөхцөлтэйгөөр (түүний дотор, LIBOR + 6.50%-иас ихгүй хувийн хүүтэйгээр) дахин татан авч болно;

(iv) Рио Тинто нь ОТ ХХК-иас зөвшөөрөгдсөн мөнгөн хөрөнгө татах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор (ii) заалтын дагуу хадгалуулсан мөнгөн хөрөнгөөс олголт хийнэ;

(v) ОТ ХХК-иас нэхэмжлэх Төслийн санхүүжилтийн баталгааны шимтгэл нь Далд уурхайн Төслийн

санхүүжилтийн үндсэн дүн, хүү, шимтгэл, төлбөрийн тухайн үеийн үлдэгдлийн 1.9%-иас хэтрэхгүй байхыг Туркойс Хилл болон Рио Тинто зөвшөөрч байна;

- (vi) Төслийн санхүүжилтийн баталгааны шимтгэл нь зөвхөн, (ii) заалтын дагуу Рио Тинто-ийн тайлан тэнцэлд тухайн үед бүртгэгдсэн байгаа мөнгөн хөрөнгийн дүн Рио Тинто-ийн Төслийг гүйцэд хэрэгжүүлэх баталгаанд тусгагдсан дүнгээс бага байвал тооцогдоно. Ингэснээр, Далд уурхайн Төслийн санхүүжилтийн нийт хугацааны туршид үйлчлэх баталгааны шимтгэлийн бодит хувь нь 1%-иас бага болтол буурах тооцоотой байна.

5.6 Монголын тал нь Далд уурхайн Төслийн зээлдүүлэгчдийн зүгээс тавих Монгол Улсын хууль тогтоомж, ХөОГ, НӨОДТХНГ-нд нийцэж буй бүхий л шаардлагуудыг хангахад хэрэгцээтэй бүх арга хэмжээг авч хэрэгжүүлж, дэмжиж ажиллана. Үүнд Далд уурхайн Төслийн Санхүүжилтийн гэрээнүүдийн дагуу шаардагдах барьцаалах эрхийг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд бүрэн баталгаажуулах ажил багтана. Зээлийн санхүүжилт авахад шаардагдах энэхүү барьцаанд ОТ ХХК-ийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд, ХөОГ болон НӨОДТХНГ-нд тусгагдсан ОТ ХХК-ийн эрхүүд, ба ОТ ХХК-ийн үл хөдлөх хөрөнгө хамаарна.

## **6. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ОЛОН УЛСЫН ЖИШИГ ҮНЭД ТУЛГУУРЛАСАН АМНАТ**

6.1 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ)-ийг Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 47.2.1 ба ХөОГ-ний 3.12.1-т заасны дагуу тооцох бөгөөд Бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг энэхүү 6 дугаар зүйлд заасан зарчмаар тогтооно.

6.2 Бүтээгдэхүүн гэдэг нь доорх (a)-(d) заалтуудын дагуу дээж авч сорьцын шинжилгээгээр агууламжийг нь тодорхойлсон, хуурай тонноор хэмжигдсэн баяжмалд агуулагдах зэс, алт, мөнгийг хэлнэ.

(a) Худалдан авагчид худалдсан баяжмалын багц бүрээс гурван дээж авч, нэгийг нь борлуулалтын гэрээний зориулалтаар ОТ ХХК-ийн гэрээт лабораторид шинжлүүлж, хоёр дахийг нь Геологийн төв лабораторид өгнө.

(b) ОТ ХХК-ийн гэрээт лабораторийн хийсэн шинжилгээний үр дүнг гаргасан даруйд нь Геологийн төв лабораторид шууд шилжүүлнэ.

(c) ОТ ХХК-ийн гэрээт лабораторийн дүгнэлтэд үндэслэн борлуулах багц бүтээгдэхүүний металлын агуулгыг тодорхойлно. Уг лабораторийн дүгнэлтийг Геологийн төв лаборатори эргэлзээтэй гэж үзвэл Геологийн төв лаборатори нь гурав дахь дээжийг Геологийн төв лаборатори болон ОТ ХХК-ийн хамтран томилох олон улсад нэр хүнд бүхий хөндлөнгийн лабораторид өгч шинжлүүлэхийг ОТ ХХК-иас шаардаж болох бөгөөд энэ тохиолдолд уг хөндлөнгийн лабораторийн дүгнэлтийг дагаж мөрдөнө.

(d) Борлуулалтын үнэлгээнээс боловсруулалтын зардал (түүний

дотор хайлуулах ба цэвэршүүлэх зардал), тээврийн зардлын зөрүү, торгууль, хорогдлыг хасахгүй.

- 6.3 Борлуулалтын үнэлгээг тогтоохдоо олон улсын зах зээлийн үнийг баримтална. Үүнд:
- (a) Зэс – тухайн тээвэрлэлт хийгдсэн сарын “Металс Дэйли”-ээс зарласан Лондонгийн Металлын Биржийн А зэрэглэлийн зэсийн үнийн саналын сарын дунджийг;
  - (b) Алт – тухайн тээвэрлэлт хийгдсэн өдрийн “Металс Дэйли”-д нийтлэгдсэн, Лондонгийн Алтны Захын Холбоо (LBMA)-оос зарласан үнийг;
  - (c) Мөнгө – тухайн тээвэрлэлт хийгдсэн өдрийн “Металс Дэйли”-д нийтлэгдсэн, Лондонгийн Алтны Захын Холбооноос зарласан спот үнийг тус тус баримтална.
- 6.4 6.3-т заасан зах зээлийн үнийн механизмуудаас аль нэг нь ашиглагдах боломжгүй болсон тохиолдолд Талууд харилцан ойлголцож, 6.3-т заасан механизмуудтай аль болох дүйцэхүйц олон улсын зах зээлийн үнийг тооцох өөр суурийг тогтооно.
- 6.5 ОТ ХХК нь Оюу Толгойн баяжмалын борлуулалт эхэлснээс хойш борлуулсан Бүтээгдэхүүнд ногдох АМНАТ-ийг 6.1 ба 6.3-т заасан зарчмын дагуу дахин тооцоолох бөгөөд ийнхүү дахин тооцоолсны үндсэн дээр гарах татварын аливаа зөрүү төлбөрийг энэхүү Төлөвлөгөөнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Татварын Ерөнхий Газарт төлнө.

## 7. НЭМЭЛТ ЗҮЙЛ

- 7.1 Санхүүжилтийн хугацааны эцсээс 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх 5 жилийн хугацаанд Айвенхоугийн Санхүүжүүлэгч (НӨОДТХНГ-нд тодорхойлсон) нь НӨОДТХНГ-ний 11.1(a) эсвэл 13.1(a)-д туссанаар ЭОТ-гоос нийлүүлэхгүй байхаар заасны дагуу, ЭОТ-гоос Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн нийлүүлэхийг Туркойс Хилл зөвшөөрөв. Гэхдээ ЭОТ-гоос Шаардсан мөнгөн хөрөнгийн зөвхөн Далд уурхайн Үе шатны Капитал зардал болон Үйл ажиллагааны зардал (НӨОДТХНГ-нд заасан)-ын санхүүжилттэй холбогдох дүнг нийлүүлэх бөгөөд Далд уурхайн Үе шатны Капитал зардал болон Үйл ажиллагааны зардлыг НӨОДТХНГ-ний 14-т заасны дагуу гуравдагч этгээдийн төслийн санхүүжилтээр бүхэлд нь санхүүжүүлэх саналуудыг дэмжих асуудалд ЭОТ-н зүгээс бизнесийн зарчмын дагуу хандана. Айвенхоугийн Санхүүжүүлэгч нь НӨОДТХНГ-ний 11 эсвэл 13-т заасныг үндэслэн уг санхүүжилтийг нийлүүлэх бөгөөд Санхүүжилтийн хугацаа дуусгавар болсны дараах аливаа санхүүжилтээс тооцох хүүгийн хувь хэмжээ нь LIBOR + 6.5%-иас ихгүй байна.
- 7.2 Энэхүү Төлөвлөгөөнд гарын үсэг зурах өдрийн байдлаар ХөОГ болон НӨОДТХНГ-г аль нэг Тал ноцтойгоор болон/эсвэл санаатайгаар зөрчөөгүй болохыг Тал тус бүр хүлээн зөвшөөрөв.
- 7.3 ОТ ХХК нь ЭОТ ХХК-тай үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах бөгөөд энэхүү гэрээнд ЭОТ нь уг үйлчилгээг үзүүлэхэд хангалттай туршлага, мэдлэгтэй бөгөөд санал болгож буй үйлчилгээ нь ОТ ХХК-ийн бизнесийн бодит

хэрэгцээг хангаж байгаа тохиолдолд ОТ ХХК-ийн өөрийн хүсэлтээр ЭОТ-оос үйлчилгээ авч, авсан үйлчилгээндээ тухай бүрт нь төлбөр төлөх тухай тусгасан байна.

- 7.4 Монгол улсыг хөрөнгө оруулагчдад ээлтэй зах зээл хэмээн сурталчилах чиглэлд Рио Тинто Монголын талд зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлнэ.

## 8. БУСАД ЗҮЙЛ

- 8.1 НӨОДТХНГ-ний 23 дугаар бүлэгт заасан Маргаан шийдвэрлэх журам (өөрөөр заагаагүй тохиолдолд) энэхүү Төлөвлөгөөнд хамаарна.
- 8.2 Энэхүү Төлөвлөгөөнд зөвхөн бүх талуудын гарын үсгээр баталгаажсан бичгийг үндэслэж өөрчлөлт оруулна.
- 8.3 Энэхүү Төлөвлөгөөг Монгол Улсын хууль тогтоомж, ХөОГ болон НӨОДТХНГ-ий хүрээнд зохицуулж, тайлбарлана.
- 8.4 Энэхүү Төлөвлөгөөг англи, монгол хэлээр тус бүр 7 хувь үйлдэж, Талууд хэл тус бүр дээрх нэг хувийг хадгална. Монгол, англи хэл дээрх хувилбарууд нь адил хүчинтэй байх бөгөөд хоёр өөр хэл дээрх хувилбаруудын хооронд зөрүү гарвал англи эх хувилбарыг баримталж байхаар Талууд тохиролцов.

Талууд энэхүү Төлөвлөгөөг зохих ёсоор эрх олгосон төлөөлөгчдөөрөө дамжуулан тус тусын нэрийн өмнөөс үйлдсэн бөгөөд дээр дурьдсан өдөр хүргүүлсэн болохыг үүгээр нотолж байна:

**Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж**      **Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийг төлөөлж**

Гарын  
үсэг \_\_\_\_\_

Он,сар,өдөр

Гарын  
үсэг \_\_\_\_\_

Он,сар,өдөр

**Баянжаргалын Бямбасайхан**  
Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх  
захирал

**Даваадоржийн Ганболд**  
Гүйцэтгэх захирал

**Туркойс Хилл Ресурсес Лимитед**  
**компанийг төлөөлж**

**Ти Эйч Ар Оюу Толгой Лтд. компанийг**  
**төлөөлж**

Гарын  
үсэг \_\_\_\_\_

Он,сар,өдөр

Гарын  
үсэг \_\_\_\_\_

Он,сар,өдөр

---

**Жефри Тайгэсэн**  
Гүйцэтгэх захирал

---

**Жефри Тайгэсэн**  
Гүйцэтгэх захирал

**Оюу Толгой Нидерланд БиВи  
компанийг  
төлөөлж**

**Рио Тинто Интернэшнл Холдингс  
Лимитед компанийг төлөөлж**

Гарын  
үсэг \_\_\_\_\_  
Он,сар,өдөр \_\_\_\_\_

Гарын  
үсэг \_\_\_\_\_  
Он,сар,өдөр \_\_\_\_\_

---

**Жефри Тайгэсэн**  
Гүйцэтгэх захирал

---

**Жан-Себастьян Жак**  
Зэс-нүүрсийн группын Гүйцэтгэх захирал

**Оюу Толгой ХХК-ийг төлөөлж**

Гарын үсэг \_\_\_\_\_  
Он,сар,өдөр \_\_\_\_\_

**Эндрю Вүүдлэй**  
Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх Ерөнхий Захирал